



Аудитын код: САГ-2018/8/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунбилэг
Утас: 322071 Цахим хаяг: oyunbilegs@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn


Ахлах аудитор Г.Жавхлан
Утас: 261628 Цахим хаяг: javkhlang@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	4
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил.....	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.5	Дотоод хяналт.....	8
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.7	Шилэн дансны мэдээлэл	8
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	8
2.9.2	Төсвийн гүйцэтгэлийн талаар.....	9
2.9.3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	9
2.9.4	Орлогын талаар	9
2.9.5	Авлагын талаар.....	9
2.9.6	Өр төлбөрийн талаар	9
2.9.7	Хариуцлага тооцох саналын талаар.....	10
2.9.8	Урьдчилж гарсан зардлын талаар	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	10
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
2.16	Аудитаар тооцсон үр өгөөж.....	11
3	Менежментийн захидал	12
3.1	САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН	13
3.2	нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар.....	14
3.3	орлогын талаар.....	15
3.4	авлагын талаар	16
3.5	Өр төлбөрийн талаар	17
3.6	Урьдчилж гарсан зардлын талаар	18
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	19
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	19
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	20
4.2.1	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23



4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	24
4.4	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27



1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ГАНТӨМӨР
ТАНАА

2018.03.23 № 01/804
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Yawsan_Bichig\2018\0323SAG27.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0323SAG27.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 5-наас 2018 оны 03 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан хариуцаж хэрэгжүүлэв.

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Стандарт, хэмжил зүйн газраас Төсвийн тухай хуулийн хугацаанд багтааж 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Стандарт, хэмжил зүйн газар санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/ зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Стандарт, хэмжил зүйн газрын эрхэм зорилго Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршиж байна.

Тус байгууллага дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах бодлогоор дэмжиж, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхийг нэмэгдүүлж олон улсын түвшинд хүргэх;
- Олон улсын шаардлагад нийцсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн тогтолцоог бий болгох, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлчилгээний болон удирдлагын тогтолцоо (ISO 9001, ISO 14000 НАССР)-ны баталгаажуулалтын үйл ажиллагаагаар худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцлийг бүрдүүлэх;
- Сорьцын баталгааг олон улсын түвшинд хүргэх, үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулуу тодорхойлох үйлчилгээг олон улсын стандартын дагуу хийж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;

Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Стандарт, хэмжил зүйн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан.



Стандарт, хэмжил зүйн газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "Интер актив"-ийн програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Стандарт, хэмжил зүйн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байна гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Стандарт, хэмжил зүйн газар 2017 оны төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангаар 5,226.7 сая төгрөгийн батлагдсан нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгээс 5,128.3 сая төгрөг зарцуулж, нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 98.1 хувьтай тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Стандарт, хэмжил зүйн газар байгууллагын www.masm.gov.mn веб хуудаст шилэн дансны цэсийг холбосон ба Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харьяа байгууллагуудын аудитын тайлангуудад Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн алдаа, зөрчил илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 6 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Стандарт, хэмжил зүйн газрын харьяа 21 байгууллагад төрийн аудитын байгууллагаас аудит хийсэн ба 15 байгууллагад Зөрчилгүй санал дүгнэлт, 1 байгууллагад Хязгаарлалттай санал дүгнэлт тус тус өгч 4 байгууллагын тайланд итгэл үзүүлж, 1 байгууллагын тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Зөрчлийн нэгтгэлээр нийт 652.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 6.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөр барагдуулах акт, 58.6 сая төгрөгийн зөрчилд 8 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 506.4 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгч, 80.8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 тус тус хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.9.2 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Стандарт, хэмжил зүйн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 5,226.7 сая төгрөгийн нийт зарлага ба цэвэр зээлийн батлагдсан төсөвтэйгөөс 5,128.3 сая төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг нийт дүнгээр нь хэтрүүлээгүй боловч гэрээт ажлын хөлсний зардлыг 28.1 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлыг 3.4 сая төгрөгөөр, байрны түрээсийн зардлыг 1.7 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 7.7 сая төгрөгөөр, БҮТЭЗ-ийн зардлыг 1.6 сая төгрөгөөр, эм бэлдмэлийн зардлыг 0.3 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 0.7 сая төгрөгөөр нийт дүнгээр 43.5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын ангиллыг хэтрүүлэн зарцуулахгүй байх, мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллалаагүй байгаа учраас зөрчил арилгуулах албан шаардлага өгөх;

2.9.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Стандарт, хэмжил зүйн газар системийн хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөн ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.9.4 Орлогын талаар

Стандарт, хэмжил зүйн газар нь тайлант онд 39.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулалгүй нэмэлт дансаар авч, үйл ажиллагаанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төсөлд өөрийн орлогыг тусган батлуулах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.9.5 Авлагын талаар

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 119.4 сая төгрөгийн авлага толилуулсан ба харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсны үр дүнд өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэгдээгүй байсан 89.0 сая төгрөгийг нэмж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үүссэн авлагыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.9.6 Өр төлбөрийн талаар

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 96.0 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан ба өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос дорвитой буураагүй нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Шийдвэрлэсэн нь: Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.9.7 Хариуцлага тооцох саналын талаар

Төрийн аудитын байгууллагаас Ховд аймгийн СХЗХ-ийн тайлант оны санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас тайлант оны санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн Ховд аймгийн СХЗХ-ийн дарга, нягтлан бодогч нарт Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "...санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан...албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" заалтыг үндэслэн арга хэмжээ авах албан шаардлага СХЗГ-ын даргад хүргүүлэх;

2.9.8 Урьдчилж гарсан зардлын талаар

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 42.0 сая төгрөгийн он дамжсан урьдчилж гарсан зардлын үлдэгдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар менежментийн захидлаар аудитын зөвлөмж өгөх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Европын холбооноос СХЗГ-т хэрэгжүүлсэн төслийн хүрээнд үнэ төлбөргүй тараагдах 300 номыг тус газрын удирдлага нэг бүрийг нь 200.0 мянган төгрөгөөр үнэлэн худалдаж, орлогыг нь зориулалт бусаар зарцуулсан талаар хэвлэл мэдээлэл, цахим хуудсуудад нийтлэгдсэн бөгөөд одоогийн байдлаар дээрх асуудлыг Авилгатай тэмцэх газраас шалгаж байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

СХЗГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт нийт 652.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 6.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөр барагдуулах акт, 58.6 сая төгрөгийн зөрчилд 8 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 506.4 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгч, 80.8 сая төгрөгийн алдаанд санхүүгийн тайланд 7 залруулга хийсэн байна.


2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

СХЗГ-ын 2016 жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг УАГ-аас баталгаажуулж, аудитын дүнгээр 6 зөвлөмж өгснийг 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн 9,528.6 сая төгрөгийн нийт зардлын 2 хувиар буюу 190.5 сая төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, түвшин өөрчлөгдөөгүй болно.



2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 190.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинг тогтоосон бөгөөд илэрсэн нийт материаллаг алдаа нь 64.9 сая төгрөг буюу материаллаг байдлын түвшингөөс даваагүй болно.

Стандарт, хэмжил зүйн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖ

Аудитаар насжилт ихтэй, уламжлалт эрсдэл өндөр, авлага /119.4 сая төгрөг/, өр төлбөр /96.0 сая төгрөг/, урьдчилж гарсан зардал /42.0 сая төгрөг/ дансдад горим, нарийвчилсан сорил хэрэгжүүлж, аудитын зөвлөмжийг менежментийн захидлаар өгсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар нь аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласнаар 100.0 сая хүртэлх төгрөгийн үр өгөөж бий болно гэж тооцлоо.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Стандарт, хэмжил зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Стандарт, хэмжил зүйн газрын харьяа 21 байгууллагад төрийн аудитын байгууллагаас аудит хийсэн ба 15 байгууллагад Зөрчилгүй санал дүгнэлт, 1 байгууллагад Хязгаарлалттай санал дүгнэлт тус тус өгч 4 байгууллагын тайланд итгэл үзүүлж, 1 байгууллагын тайланг аудитын түүвэрт хамруулсан байна. Зөрчлийн нэгтгэлээр нийт 652.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 6.3 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөр барагдуулах акт, 58.6 сая төгрөгийн зөрчилд 8 зөрчил арилгуулах албан шаардлага тус тус тогтоож, 506.4 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж өгч, 80.8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**3.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧГИЙН ТАЛААР**

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Стандарт, хэмжил зүйн газар системийн хэмжээнд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй явж ирсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөн ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бүрэн дүүрэн хэрэгжихгүй байх, тайлан бүртгэлийн үйл ажиллагаа нэгдсэн стандартаар илэрхийлэгдэхгүй байх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 ОРЛОГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Стандарт, хэмжил зүйн газар нь тайлант онд 39.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг батлуулалгүй нэмэлт дансаар авч, үйл ажиллагаанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт сулрах;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг” гэж заасны дагуу батлагдсан төлөвлөгөөнд өөрийн орлогыг тусган батлуулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 119.4 сая төгрөгийн авлага толилуулсан ба харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсны үр дүнд өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэгдээгүй байсан 89.0 сая төгрөгийг нэмж тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

ҮАГ-ын зөвлөмж

Үүссэн авлагыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах ;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.5 ӨР ТӨЛБӨРИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 96.0 сая төгрөгийн өр төлбөр толилуулсан ба өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос дорвитой буураагүй нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

ҮАГ-ын зөвлөмж

Хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.6 Урьдчилж гарсан зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Стандарт, хэмжил зүйн газрын тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 42.0 сая төгрөгийн он дамжсан урьдчилж гарсан зардлыг тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурах;

ҮАГ-ын зөвлөмж

Урьдчилж гарсан зардлыг барагдуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12 сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		357,166.8	443,234.1
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3а, 3б	5,213.1	4,424.5
АВЛАГА	5а,5б,6а,6б	30,488.0	119,475.9
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ	7а,7б	42,000.0	42,000.0
БАРАА МАТЕРИАЛ	8а,8б,8в	279,267.2	277,289.7
НӨӨЦИЙН ХӨРӨНГӨ	9а	198.5	44.0
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,623,887.9	4,966,605.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б,12в	5,623,887.9	4,966,605.4
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
Биет бус хөрөнгө	13	3,434.7	2,178.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,981,054.7	5,409,839.5
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а,15б	104,614.3	96,082.8
Өглөг	17а,17б	101,950.3	95,018.8
Урьдчилж орсон орлого	18а,18б	2,954.8	6,739.5
Бусад	20а,20б		
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		104,614.3	96,082.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ		5,876,440.4	5,313,756.7
Засгийн газрын хувь оролцоо		5,876,440.4	5,313,756.7
ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО		0.0	0.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,876,440.4	5,313,756.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН НИЙТ ДҮН VI=IV+V		5,981,054.7	5,409,839.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		9,605,494.3	8,981,334.2
Татварын орлого			
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а,1б	4,618,078.2	3,696,770.9
татварын бус орлого		4,546,491.8	3,696,770.9
Төсөв байгууллагын өөрийн орлого		4,540,572.0	3,625,225.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,986,400.6	3,499,659.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,550.0	10,237.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		30,475.6	115,328.7
Түрээсийн орлого		4,889.8	0.0
Үйл ажиллагааны бусад орлого	1а,1б	1,030.0	71,545.5
Буцалтгүй тусламжийн орлого	1а,1б	71,586.4	0.0
Хандив тусламж /гадаад/		71,586.4	0.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,987,416.1	5,284,563.2
Улсын төвлөрсөн төсвөөс		4,922,893.2	5,170,489.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		4,922,893.2	5,170,489.9
Нэмэлт санхүүжилтийн орлого		45,534.4	114,073.3
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		43,419.2	40,093.1
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7.0	73,980.2
Төсвийн урамшуулал		2,108.1	0.0
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		18,988.5	0.0
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		18,988.5	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а,2б	10,425,982.7	9,543,271.0
УРСГАЛ ЗАРДАЛ		10,425,982.7	9,543,271.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,488,549.8	5,543,953.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		3,380,206.0	3,393,711.0
Үндсэн цалин		2,991,496.8	2,964,815.8
Нэмэгдэл		887.2	0.0
Унаа хоолны хөнгөлөлт		155,346.0	209,641.4
Гэрээт ажлын хөлс		232,476.1	219,253.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		369,456.0	373,583.0
Тэтгэврийн даатгал		300,375.2	296,856.1
Тэтгэмжийн даатгал		13,315.0	18,031.7
ҮОМШӨ-ний даатгал		16,934.0	16,901.8
Ажилгүйдлийн даатгал		4,685.4	4,122.2

Эрүүл мэндийн даатгал		34,146.4	38,171.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		272,711.1	279,899.6
Гэрэл, цахилгаан		60,604.6	73,619.6
Түлш, халаалт		150,801.4	156,394.0
Цэвэр, бохир ус		21,412.9	18,170.6
Байрны түрээс		39,892.1	31,715.4
Хангамж, бараа материалын зардал		141,733.8	173,088.3
Бичиг хэрэг		30,746.2	41,943.5
Тээвэр, шатахуун		52,816.6	69,094.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		33,941.7	32,445.3
Ном, хэвлэл		236.5	0.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		4,481.7	3,196.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,206.7	20,296.0
Бараа материал акталсны зардал		3,304.3	6,111.9
Нормативт зардал		6,586.0	49,381.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		3,868.8	45,057.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл		2,717.2	4,324.0
Эд хогшил, урсгал засварын зардал		97,177.3	33,838.4
Багаж, техник, хэрэгсэл		58,690.4	2,571.5
Тавилга		0.0	238.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		1,512.6	984.0
Урсгал засвар		36,974.3	30,044.8
Томилолт, зочны зардал		82,831.6	146,631.4
Гадаад албан томилолт		2,989.7	0.0
Дотоод албан томилолт		79,841.9	146,631.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		196,373.6	188,794.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		91,047.3	68,698.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,220.0	3,329.0
Даатгалын үйлчилгээ		4,638.2	4,362.0
Тээврийн хэрэгслийн татвар		1,874.6	1,610.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо		332.0	413.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,127.0	2,020.8
Газрын төлбөр		1,576.1	2,034.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		37,615.4	51,908.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		53,943.0	54,417.4
Бараа үйлчилгээний бусад зардал		941,474.3	905,025.8
Бараа үйлчилгээний бусад зардал		46,599.0	60,127.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		15,498.0	24,271.6
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		879,377.4	820,627.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,937,432.9	3,999,318.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг		141,759.2	161,759.1



Засгийн газрын гадаад шилжүүлэг		141,759.2	161,759.1
Бусад урсгал шилжүүлэг		282,603.8	360,932.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		18,510.4	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		2,742.6	0.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		0.0	3,000.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		254,090.2	240,960.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		7,260.6	116,971.5
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		4,513,069.9	2,149,286.9
Төвлөрүүлэх шилжүүлэг		3,994,924.1	2,143,564.8
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		0.0	1,327,340.1
Төвлөрүүлэх шилжүүлэг		0.0	1,333,062.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-820,488.4	-561,936.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,644.9	8,836.6
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		3,644.9	8,836.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-824,133.3	-570,773.5

4.2.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхий хувь оролцоо	Нийт хөрөнгө/өмч
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,700,295.4		6,700,295.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	278.3		278.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,700,573.7		6,700,573.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00		0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00		0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00		0.00
Тайлант үеийн үр дүн	-824,133.3		-824,133.3
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,876,440.4		5,876,440.4
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,876,440.4		5,876,440.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,089.8		8,089.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,884,530.2		5,884,530.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0		0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.0		0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0		0.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0		0.0
Тайлант үеийн үр дүн	-570,773.5		-570,773.5
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,313,756.7		5,313,756.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,564,757.8	8,806,790.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,981,516.7	3,496,530.6
Нийтлэг татварын бус орлого	3,981,516.7	3,496,530.6
Төсөв байгууллагын өөрийн орлого	3,943,904.3	3,440,247.7
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,943,904.3	3,429,980.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	10,267.7
Бусад орлого	37,612.4	56,282.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,583,241.1	5,310,259.4
Улсын төвлөрсөн төсвөөс	4,922,893.2	5,170,489.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,922,893.2	5,170,489.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	123,105.1	109,785.1
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,631.3	1,600.0
ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	101,005.7	30,293.1
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,896.8	77,892.0
Төсвийн урамшуулал	6,520.0	0.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	518,145.8	0.0
Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	51.4	0.0
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,096.9	29,984.4
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	19,096.9	29,984.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,480,660.0	8,770,763.0
УРСГАЛ ЗАРДАЛ	9,480,660.0	8,770,763.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,538,042.8	4,725,692.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,369,040.1	3,362,008.8
Үндсэн цалин	2,907,669.4	2,871,450.9
Унаа хоолны хөнгөлөлт	186,049.1	190,678.5
Гэрээт ажлын хөлс	275,321.6	299,879.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,894.5	368,478.8
Тэтгэврийн даатгал	234,003.0	237,471.0
Тэтгэмжийн даатгал	25,857.4	31,862.0
ҮОМШӨ-ний даатгал	33,067.4	27,007.0
Ажилгүйдлийн даатгал	7,607.9	6,924.8
Эрүүл мэндийн даатгал	66,358.9	65,214.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,019.4	283,749.3
Гэрэл, цахилгаан	74,267.3	78,123.3
Түлш, халаалт	154,292.7	152,719.7
Цэвэр, бохир ус	22,507.1	18,724.1
Байрны түрээс	39,952.3	34,182.3
Хангамж, бараа материалын зардал	136,547.7	161,846.9
Бичиг хэрэг	26,182.9	34,448.0
Тээвэр, шатахуун	55,078.4	71,574.6

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,199.0	32,866.3
Ном, хэвлэл	236.5	0.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,291.9	3,572.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,559.1	19,385.3
Нормативт зардал	6,828.4	49,855.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,441.4	45,489.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,387.0	4,365.8
Эд хогшил, урсгал засварын зардал	39,581.2	73,514.5
Багаж, техник, хэрэгсэл	205.0	3,529.6
Тавилга	0.0	0.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,731.7	984.0
Урсгал засвар	37,644.5	69,001.0
Томилолт, зочны зардал	81,549.0	144,565.1
Гадаад албан томиллолт	2,989.7	0.0
Дотоод албан томиллолт	78,559.2	144,565.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	183,857.3	187,455.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,746.2	68,292.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,620.0	3,335.8
Даатгалын үйлчилгээ	4,638.2	4,347.8
Тээврийн хэрэгслийн татвар	1,927.2	1,643.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	368.9	415.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,940.0	2,020.8
Газрын төлбөр	1,557.2	2,037.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	37,617.9	51,908.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	54,441.6	53,453.2
Бараа үйлчилгээний бусад зардал	62,725.2	94,218.4
Бараа үйлчилгээний бусад зардал	46,599.0	67,660.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,126.2	26,557.4
ТАТААС	978.0	0.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	978.0	0.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	978.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,941,639.3	4,045,070.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	141,759.2	161,789.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	30.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	141,759.2	161,759.1
Бусад урсгал шилжүүлэг	283,927.8	407,469.8
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	19,096.9	29,861.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,514.1	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	260,073.3	237,360.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,243.4	140,247.5
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,515,952.3	2,142,707.8
Төвлөрүүлэх шилжүүлэг	3,997,806.5	2,142,707.8
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	41.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	41.0
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	1,333,062.2
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	1,333,062.2



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	84,097.8	36,027.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	85,485.6	36,815.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,485.6	36,815.7
Дотоод эх үүсвэрээр	85,485.6	36,815.7
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,485.6	36,815.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-85,485.6	-36,815.7
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,387.8	-788.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,601.0	5,213.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,213.1	4,424.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,226,761.5	5,128,308.6	98,452.9	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,226,761.5	5,128,308.6	98,452.9	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,630,890.8	4,615,968.3	14,922.5	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,362,072.4	3,362,008.8	63.6	100.0
210101	Үндсэн цалин	2,871,329.3	2,871,450.9	-121.6	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	219,034.3	190,678.5	28,355.8	87.0
210105	Гэрээт ажлын хөлс	271,708.8	299,879.5	-28,170.7	110.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	368,356.5	368,478.8	-122.3	100.0
210201	Тэтгэврийн даатгал	234,526.2	237,471.0	-2,944.8	101.3
210202	Тэтгэмжийн даатгал	33,457.7	31,862.0	1,595.7	95.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,765.8	27,007.0	-241.2	100.9
210204	Ажилгүйдлийн даатгал	6,691.5	6,924.8	-233.3	103.5
210205	Эрүүл мэндийн даатгал	66,915.3	65,214.0	1,701.3	97.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	293,288.2	287,190.8	6,097.4	97.9
210301	Гэрэл, цахилгаан	74,688.7	78,123.3	-3,434.6	104.6
210302	Түлш, халаалт	163,288.2	156,161.2	7,127.0	95.6
210303	Цэвэр, бохир ус	22,906.4	18,724.1	4,182.3	81.7
210304	Байрны түрээс	32,404.9	34,182.3	-1,777.4	105.5
2104	Хангамж, бараа материалын зардал	159,546.0	159,399.9	146.1	99.9
210401	Бичиг хэрэг	25,739.1	33,464.2	-7,725.1	130.0
210402	Тээвэр, шатахуун	72,631.7	70,453.3	2,178.4	97.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,968.8	32,866.3	5,102.5	86.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,827.2	3,572.7	2,254.5	61.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,379.2	19,043.3	-1,664.1	109.6
2105	Нормативт зардал	49,334.2	49,805.2	29.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,122.9	45,489.4	366.5	100.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,211.3	3,815.8	395.5	90.6

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,001.7	54,985.4	16.3	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,455.0	4,340.7	114.3	97.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425.6	774.0	651.6	54.3
210604	Урсгал засвар	49,121.1	49,870.8	-749.7	101.5
2107	Томилолт, зочны зардал	114,645.9	114,595.8	50.1	100.0
210702	Дотоод албан томилолт	114,645.9	114,595.8	50.1	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	149,237.5	140,638.3	8,599.2	94.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,072.2	73,384.4	7,687.8	90.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,818.4	3,335.8	482.6	87.4
210803	Даатгалын үйлчилгээ	4,429.2	4,347.8	81.4	98.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,832.7	1,643.3	189.4	89.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	415.6	415.6	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,154.2	2,020.8	133.4	93.8
210807	Газрын төлбөр	2,048.6	2,037.4	11.2	99.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	53,466.6	53,453.2	13.4	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,408.4	79,365.2	43.2	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,814.3	53,827.7	-13.4	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,594.1	25,537.4	56.7	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	595,870.7	512,340.3	83,530.4	86.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	161,759.2	161,789.8	-30.6	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	30.7	-30.7	0.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	161,759.2	161,759.1	0.1	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	434,111.5	350,550.5	83,561.0	80.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	319,061.5	237,360.5	81,701.0	74.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,050.0	113,190.0	1,860.0	98.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,226,761.5	5,128,312.4	98,449.1	98.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,226,761.5	5,128,189.8	98,571.7	98.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,226,761.5	5,128,189.8	98,571.7	98.1
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	122.6	-122.6	0.0
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.0	122.6	-122.6	0.0



4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	14.5	-14.5	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	18.3	-18.3	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	786.0	768.0	18.0	97.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	20.0	20.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	20.0	20.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	383.0	383.0	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	29.0	29.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	233.0	235.0	-2.0	100.9
620003	Үйлчлэх ажилтан	67.0	71.0	-4.0	106.0
620004	Гэрээт ажилтан	54.0	48.0	6.0	88.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	383.0	365.0	18.0	95.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	255.0	238.0	17.0	93.3
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7.0	7.0	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	67.0	78.0	-11.0	116.4
650010	Гэрээт ажилтан	54.0	42.0	12.0	77.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ